



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2018 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулааны 3 дугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 348,306,032.10 (гурван зуун дөчин найман сая гурван зуун зургаан мянга гучин хоёр төгрөг арван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Дулааны 3 дугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Дамдинсүрэн, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баярсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТЭЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

D:\Huraldaanii material\2018.02.07\togtool\03docx

0001487

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн  
47 дугаар тогтоолын хавсралт



**"Дулааны 3 дугаар цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн балансаас  
"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн балансад  
шилжүүлэх хөрөнгийн жагсаалт**

Д/д	Барилга байгууламжийн нэр, байршил	Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо	Нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан эзлэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, "Эрчим хотхон" ТП	1	Барилга	2015	ш	1	95,748,261.60	0	95,748,261.60
		2	ТП-ны тоноглол	2015	ком	1	153,912,317.80	0	153,912,317.80
		3	Цахилгаан дамжуулах кабелийн шугам /АСБ 3*95 мм <sup>2</sup> , 6кВ/	2015	м	1820	67,319,291.90	0	67,319,291.90
2	Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, Ажилчны гудамж, 10/2, 10/3-р байр 198 айлын орон сууц	4	Орон сууцны гадна цахилгааны хос кабель	2017	м	557	31,326,160.80	0	31,326,160.80
<b>НИЙТ ДҮН:</b>							<b>348,306,032.10</b> (гурван зуун дөчин найман сая гурван зуун зургаан мянга гучин хоёр төгрөг арван мөнгө)	<b>0</b>	<b>348,306,032.10</b> (гурван зуун дөчин найман сая гурван зуун зургаан мянга гучин хоёр төгрөг арван мөнгө)